



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

「 А.Айбекийг ажилд түр томилох тухай 」

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 01/5473 тоот албан бичиг, Авлигатай тэмцэх газрын 2025 оны Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай 05/6470 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Асхарын Айбекийг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал А.Айбектэй зохих журмын дагуу ажил хүлээлцүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ